



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Хотын стандартыг мөрдүүлэх, ажлын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 9.5 дахь хэсэг, Газрын дүрмийн 4.1.6 дахь заалт, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хотын стандартыг мөрдүүлэх 2023 ажлын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хотын стандартыг мөрдүүлэх, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг Газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Хотын хөгжлийн стандартын хэлтсийн дарга (Б.Ариунтуяа)-т даалгасугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

Газрын даргын 2023 оны 02 дугаар
сарын 17-ны өдрийн 116 дугаар
тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ариунтуяа
(Хотын хөгжлийн стандартын
хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Амартүвшин
(Байгаль орчны стандартын
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Ариунзаяа
(Худалдаа, үйлчилгээний
стандартын хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

Б.Батчимэг
(Барилга байгууламжийн ашиглалт
бүртгэлийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

З.Ганбат
(Барилгын стандарт, аюулгүй
байдлын хяналтын хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

Б.Тамир
(Дэд бүтцийн стандарт, хяналтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

М.Пунсалмаа
(Захиргаа, санхүүгийн хэлтсийн
Олон нийттэй харилцах ажилтан)

Нарийн бичгийн дарга:

С.Гүлдана
(Хотын хөгжлийн стандартын
хэлтсийн мэргэжилтэн)